



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН


МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№98 (98)

2021.07.26

ҮЙЛ ЯВДАЛ

БНХАУ-ЫН ТӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ХУРАНДАА ГЕНЕРАЛ ВЭЙ ФӨНХӨ ӨНӨӨДӨР МОНГОЛ УЛСАД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙЖ БАЙНА



БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалахын сайд хурандаа генерал Вэй Фөнхө Монгол Улсад албан ёсны айлчлалаа Хятадын Ардын Чөлөөлөх Армийн Агаарын цэргийн хүчний тусгай үүргийн онгоцоор "Чингис хаан" олон улсын нисэх буудалд 10:00 цагт хүрэлцэн ирснээр эхлүүлж байна.

Айлчлалын үеэр БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд Вэй Фөнхө Монгол Улсын Их хурлын дарга Г.Занданшатар т баралхаж, Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяртай албан ёсны хэлэлцээ хийх юм.

БНХАУ-ын Батлан хамгаалахын сайдын айлчлалын бүрэлдэхүүнд БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чай Вэнрүй, Цэргийн төв Зөвлөлийн Тамгын газрын орлогч дарга хошууч генерал Фөн Мижунь, Шинжааны цэргийн тойргийн орлогч командлагч хошууч генерал Ян Линь, Олон улсын цэргийн хамтын ажиллагааны газрын орлогч дарга хошууч генерал Сун Яаньчао нарын албаны бусад хүмүүс багтжээ.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ОРЛОГЧ ХАТАГТАЙ УЭНДИ ШЕРМАНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн даргын орлогч хатагтай Уэнди Шерман тэргүүтэй төлөөлөгчдийг 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Батлан хамгаалах яаманд хүлээн авч уулзав. Уулзалтад Монголын талаас ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд М.Клечески, Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Ф.Лью болон албаны бусад хүмүүс оролцов.

Сайд Г.Сайханбаяр Монгол Улсын стратегийн түнш, гуравдагч хөрш АНУ-тай батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж, бүс нутаг, дэлхий дахинд цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, энх тайван тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэгт сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. Түүнчлэн, Монгол Улсын Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд дахь оролцоогоо нэмэгдүүлэх зорилго, хүчин чармайлтын талаар танилцуулж, АНУ-ын Төрийн департаменттаас дэмжин ажиллахыг хүслээ.

Төрийн нарийн бичгийн даргын



орлогч хатагтай У.Шерман Монгол Улсын Засгийн газар мэргэжлийн ур чадвар, эр зоригоороо гайхагддаг цэрэг эрсээ дэлхий нийтийн энх тайвны үйл хэрэгт илгээж, үнэтэй хувь нэмэр оруулж байгаад Америк орон болон АНУ-ын Ерөнхийлөгчийн

нэрийн өмнөөс талархав. Түүнчлэн Монгол цэргүүдийн НҮБ, дэлхий дахины тогтвортой байдлыг хангахад нэгдэх үйлс, хүчин чармайлтад аль болох хэрэгцээтэй цагт нь дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй байдгаа илэрхийлэв.

Хатагтай У.Шерман Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн төлөөлөлтэй уулзаж, талархал илэрхийлэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 22

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.848.0	2.851.0
EUR 🇪🇺	3.365.0	3.380.0
CNY 🇨🇳	440.8	441.7
RUB 🇷🇺	37.70	40.40
JPY 🇯🇵	25.25	26.30
KRW 🇰🇷	2.35	2.57

ЗУРХАЙ

2021.07.26, /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 17

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН НАЙМАН ЦАГААН ХӨХӨГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно

Наран ургах, шингэх:

05:20-20:37

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:

Хий

Аргын тооллын 7 сарын 26, Сумъяа гараг. Билгийн тооллын 18, Чөдөр одтой, хөхөгчин гахай өдөр. Өдрийн наран 5 цаг 21 минутад мандан, 20 цаг 36 минутад жаргана. Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн.

Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэтгэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болтой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 156.733 +1513	ЭДГЭРСЭН 152.158 +2625	НАС БАРСАН 774 +7
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 3998 +69	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 283 +43	ЭДГЭРСЭН 3643 +27
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 194,793,206
Эдгэрсэн Нийт: 176,744,824
Нас барсан Нийт: 4,174,555

ДЕЛЬТА ХУВИЛБАР
АНХЛААРХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

СПОРТ



Хүн төрөлхтний баяр цэнгэл ТОКИО-2020 Олимпын XXXII наадам энэ сарын 23-нд эхлээд байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийн өмнөөс тус наадамд спортын 7 төрлөөр 12 тамирчин эрх аван оролцож байна.

Тус наадамд Монгол Улс оролцож эхэлснээс хойш Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны тамирчид тасралтгүй оролцсон байдаг бөгөөд Олимпын наадмын мөнгө, хүрэл, шагналт байрыг нийт 13 тамирчин хүртсэн байна. Зэвсэгт хүчний төлөөлөл нийт тамирчин дайчиддаа амжилтын дээдийг хүсэн ерөөе.

ОЛИМПЫН 3 ДАХЬ ӨДӨР БНХАУ-ЫН БАГ 9 МЕДАЛЬТАЙ 206 ОРНЫГ ТЭРГҮҮЛЖ ЯВНА



“Токио-2020” Зуны олимпын XXXII наадмын 3 дахь өдрийн байдлаар БНХАУ-ын үндэсний шигшээ баг 5 алт, 1 мөнгө, 3 хүрэл медальтай оролцогч 206 улс орноос тэргүүн байр эзэлж байна. Харин АНУ-ын шигшээ баг 2 алт, 2 мөнгө, 4 хүрэл нийт 8 медальтай

хоёрдугаарт бичигдэж байгаа бол олимп зохион байгуулагч Япон улсын шигшээ баг 5 алт, 1 мөнгөн медальтай удаалж байгаа аж. Дөрөвдүгээр байрт БНСУ-ын шигшээ 2 алт, 3 хүрэл медальтай 4 дүгээр байр, Оросын үндэсний олимпын хорооны баг 1 алт, 2 мөнгө, 1 мөнгөтэй 5 дугаар

байр тус тус эзэлжээ. Харин 6-10 дугаар байрт Итали /1 алт, 1 мөнгө, 2 мөнгө/, Австрали /алт, мөнгө, хүрэл тус бүр 1/, Тунис /алт, мөнгө тус бүр 1/, Канад, Нидерланд улсын шигшээ багууд тус бүр 2 мөнгөн медальтай багтсан байна.

ТОКИОГИЙН ОЛИМПЫН БОКСЧДЫН ТУЛААНЫГ МОНГОЛЫН 2 ШҮҮГЧ ДЭНСЭЛЖ БАЙНА



“Токио-2020” Зуны олимпын XXXII наадмын боксын тэмцээнийг Монгол Улсын 2 шүүгч олимпын ринг дээр гарч байгаа шилдэг боксчдын тулааныг дэнслэн шүүж байгаа юм.

Тухайлбал, Олон улсын сонирхогчдын боксын холбооны 3 од буюу олимпын зэрэглэлийн шүүгч, ОУХМ Ц.Цогтгэрэл /эмэгтэй/, олимпын зэрэглэлийн шүүгч О.Мандахбаяр /эрэгтэй/ нар шүүгчээр ажиллаж байна.

Олимпын наадамд боксын шүүгчээр ажиллаж буй монгол эмэгтэй Цэрэнхандын Цогтгэрэл одоогоос сарын өмнө Монгол Улсын ерөнхийлөгч асан Х.Баттулгын зарлигаар төрийн дээд одон Алтан гадас одонгоор шагнуулсан билээ. Тэрбээр Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайдын яамны ажилтан юм. ОУСБХ/АИБА-ны 3 од буюу олимпын зэрэглэлийн шүүгч, ОУХМ Ц.Цогтгэрэл тив, дэлхийн болон олон улсын томоохон тэмцээнийг амжилттай шүүж байсан туршлагатай шүүгч.

Харин Токиогийн олимпын шүүгчээр сонгогдсон Мандахбаярын хувьд түүний аав Р.Отгонбаяр бол 1982 онд Германд болсон боксын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль хүртэж, Монголын боксчдын анхны дэлхийн медальтан болсон тамирчин билээ.

ҮЙЛ ЯВДАЛ

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦЫГ “ДАЙЧИН АЛДАР-III” МЕДАЛИАР ШАГНАВ



ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг өөрийн тэсвэр хатуужлаар бусдыгаа үлгэрлэн цэргийн алба хаагчийн манлайллыг өндөрт өргөж чадсан ахлах ахлагч Э.Даваажамцыг багийн гишүүдийнх нь хамтаар хүлээн авч хүндэтгэл үзүүлжээ.

Тэрбээр Батлан хамгаалахын сайдын тушаалаар ахлах ахлагч Э.Даваажамцыг “Дайчин алдар-III” медалиар шагнасныг нь гардуулан өгч, мөн дурсгалын сэлмээр шагнасан бөгөөд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнээс цугласан хандивын мөнгийг хүлээлгэн өглөө.

Энэ үеэр ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал

Д.Ганзориг “Хүн бүр өөрийн зорилготой амьдардаг. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд шаргуу хөдөлмөр, шавхагдашгүй тэвчээр гаргадгийг ахлах ахлагч Э.Даваажамц үлгэрлэн харууллаа. Аливаа ажлыг дэмжих сайхан, гэхдээ тэрхүү үйл ажиллагаа өрнөж байх мөч бүрд удирдагч хүний сэтгэл санаа байнга зовниж, үргэлж “түгшүүртэй” байдаг нь нууц биш. Харин уг ажил нь бодит биелэл болж үр дүнд хүрсний дараа л бидний сэтгэл тайвширч баярлаж, бахдах сэтгэл төрдөг юм. Энэ олон хоногийн турш түүнийг дагалдаж, ар талыг нь найдвартай хангасан Э.Даваажамцын гэр

бүлийнхэнд нь талархал илэрхийлье” гэв. Мөн цаашид энэхүү гүйлтийн туршлагаа судлан судалгаа хийх нь зүйтэй. Ирээдүйн зорилгоо зөв тодорхойлж, салбартаа төдийгүй хувийн амьдралдаа улам их амжилт гаргаарай. Таны хувьд аливаад тууштай байх аваас бүх хаалга нээлттэй шүү. Гагцхүү аархаж, омогшиж болохгүй, гол нь нийгэмдээ, хамт олондоо идэвхтэй манлайлагч нь байгаарай гэдгийг захилаа.

Үүнээс гадна “Таван нүдэн” брэндийг үүсгэн байгуулагч захирал Б.Батзаяа ахлах ахлагч Э.Даваажамцад “Mongol army” цаг болон хүзүүний зүүлтийг дурсгасан юм.

ЦАХИМ ШУУДАНД

АХЛАГЧИЙН ӨДРӨӨР



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Ахлагчийн өдрийн төлөвлөгөөний дагуу зэвсгийн офицер, дэслэгч А.Төмөрбаатар, сургагч ахлагч Б.Ганбаяр, сургагч

Б.Бэрхсайхан, ахлах ахлагч А.Баасанжаргал нар ПКМ, СВД, РПК, РПГ-7в, АК-47, АКМ, АКМС, ПМ, СКС, Орос винтов, СПШ буудлагын зэвсэглэлүүдээр үзэсгэлэн гаргаж, тактик техникийн өгөгдөхүүн, задаргаа, угсаргаа хийх нормативийн дадлага, сургуулилтыг

ангийн нийт ахлагч нарын бүрэлдэхүүнтэй, хугацаат цэргийн алба хаагчдад танилцуулах ажлыг зохион байгууллаа. Ахлагч нарын бүрэлдэхүүн тус арга хэмжээнд идэвхтэй хамрагдлаа.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)